

ПАРТИЗАНУУД БА ХУВЬСГАЛЫН ҮР ДҮН

(Улс төр, түүхийн социологийн шинжилгээ)

Ч. Тамир

МУИС-ийн багш, докторант

(Цуврал өгүүллийн III дахь хэсэг. Өгүүллийн эхний хэсэг нь МУИС-ийн Түүх сэтгүүлийн VI дугаарт “Малчид ба Хувьсгалчид” нэртэйгээр, дараагийн хэсэг нь ШУА-ийн Түүхийн хүрээлэнгийн Түүхийн судлал сэтгүүлд 2009 онд “Хувьсгалын шалтгаан ба Лидерүүд” гэсэн нэртэйгээр хэвлэгдсэн болно.)

ӨГҮҮЛЛИЙН ТОВЧ УТГА: 1921 оны үндэсний ардчилсан хувьсгалд оролцсон партизануудын 1982-1986 оны гурван боть дурдатгалаас түүвэрлэн авсан 927 хүний намтар, дуртгалд судалгаа хийв. Шаардлага хангасан мэдээлэлтэй хүмүүсийн товч намтар, дурдатгалыг нэгтгэн мэдээллийг 55 үзүүлэлтээр 300 орчим шкалаар задлаж улмаар нэгтгэсэн. Контент анализ, амьдралын түүх, кейс стади аргаар дүн шинжилгээ хийж хувьсгалын шалтгаан, бүрэлдхүүн, хувьсгалын лидерүүд, хувьсгалд оролцсон бүлгүүд, хувьсгалын эрсдэлийн талаар өгүүлжээ. 1921 оны хувьсгал нь 1911 онд дэвшүүлэн тавьсан үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолын төлөөх эх оронч тэмцлийн үргэлжлэл, монголын ард түмний жам ёсны хөдөлгөөн байжээ.

ТҮЛХҮҮР ҮГС: Үндэсний гварди, орон нутгийн баг цэрэг, ардын журамт цэрэг, партизан, малчин, хөдөлмөр, социал дүр төрх

Найм. Хувьсгалын дараах партизануудын амьдрал

1. Партизануудын ангилал. Үндэсний ардчилсан хувьсгалын дараа партизануудын хувь заяа хэрхсэн вэ? Тэд шинээр үүсэн бий болсон нийгмийн тогтолцооны хаана нь байв? Аль эсвэл тэдний үүрэг нь сум сөрж дайсныг устгаад дууссан юм уу? Ер нь их хувьсгалыг ухаантнууд сэдэж, эр зоригтнууд хийж, үр дүнг адгийн шаарууд хүртдэг гэсэн онол монголын хувьсгалын жишээн дээр батлагдаж байна уу? Өмнө өгүүлсэн партизануудын дийлэнхи нь жирийн малчин, нэлээдгүй хэсэг нь хөлсний ажил, биеийн хүчийг үнэлдэг, ядуу зүдүү хүмүүс байсан. Тэдний амьдрал хувьсгалын дараа өөрчлөгдсөн үү? Өөрсдийн үндэс суурийг нь тавьсан нийгэмдээ карьераа ахиулж чадсан уу? Ар араасаа урган гарах эдгээр асуултанд бид партизануудын амьдралын түүхийг судлан хариу өгөхийг хичээсэн. Үүний тулд хамгийн эхэнд цэргээс халагдсан оныг нь сонирхсон. Судалгаанд хамрагдсан хүмүүсийн 63.5 хувь нь цэргээс халагдсан тухай яг тодорхой мэдээлэл байхгүй.

	Цэргээс халагдсан он	Тоо	Хувь
1	Тодорхой мэдээлэл байхгүй	589	63.5
2	1921	156	16.8
3	1922-1923	41	5.5
4	1924-1928	68	7.2
5	1929-1932	22	2.4
6	1933-1936	5	0.5
7	1937-1940	7	0.7
8	1941-1945	12	1.2
9	1946-1949	11	1.1
10	1950-1958	8	.1
11	Нийт	927	99.9

Нийт партизануудын 16.8 хувь нь 1921 ондоо багтаж цэргээс халагджээ. Харин 1922-1923 онд 5.5 хувь нь, 1924-1928 онд 7.2 хувь нь чөлөөлөгдсөн, нийтдээ 6 орчим хувь нь 7-оос дээш жил

III МОНГОЛЫН ОЙРХИ ТҮҮХИЙН АСУУДЛУУД

цэрэгт үргэлжлүүлэн ажиллажээ. Хэрвээ цэргээс халагдсан тухай тодорхой мэдээлэл байхгүй цэргүүдийг 1921 онд халагдсан гэж тооцвол бараг 80 хувь нь тухайн ондоо багтаж гэртээ харьжээ.

Хувьсгалын дараа партизануудыг идэвхи санаачлага, нийгэмд эзэлж байсан статусаар нь шалгуур болгож гурван бүлэгт хувааж болохоор байв. Одоо эдгээр гурван бүлгийг тус тусад нь авч үзье.

2. Малчин цэргүүд: Хувьсгал ялж дайн байлдаан дууслаа. Одоо л нэг тусгаар улс болох эхлэл тавигдаж гал усны гацуун зовлонгүй амар жимэр амьдрах нөхцөл бүрэлдэв үү? Жирийн малчнаар амьдарч байсан нэгэн хүний жишээг сонирхоё.

...Бага насандаа эцэг эхийн хамт байж, мал маллах, жин тээх зэрэг ажил хийж байгаад хувьсгалд оролцсон. Хувьсгалын дараа мал аж ахуйгаар амьдарч байжээ. (С.Сад, Ардын журамт цэргийн дуртгалууд., 1986)

Май олон цэргүүд зорилгодоо хүрсэн, одоо орон гэртээ харьж эцэг эх, хань ижил, үр хүүхэд дээрээ очиж малаа маллан амар жимэр амьдралаа гэж санаж байсан. Тэдний дотроос Богд хааны үеэс л алба хааж орон гэртээ харьж амжаагүй хүмүүс ч бий.

1909 онд цэрэгт татагдан Богдын хүрээнд очиж 1912 он хүртэл суужээ. 1918 онд Богд хаант улсын Хиагт 500 гэдэг цэрэгт татагджээ. Тэнд байхдаа Дээд шивээнээ очиж ардын журамт цэрэгт элсэн оржээ. Ардын хувьсгалын дараа Хиагтад цэргийн алба хааж байгаад 1927 онд халагджээ. 1932 оны үед Архангай, Хөвсгөл, орчмын газар гарсан хувьсгалын эсэргүү бослогыг бутцохиход идэвхтэй оролцжээ. 1941 онд МАХН-ын гишүүн болсон. Мал маллаж нэгдлийн гишүүн амьдарч байв. (Д.Дорлинг, Ардын журамт цэргийн дуртгалууд., 1985)

Ингээд ихэнхи нь төрж өссөн нутаг руугаа явж хуучин амьдралын мөрөө хөөлөө. Тэд карьер хөөгөөгүй, социал статусаа дээшлүүлэхийг төлөө улайран зүтгээгүй. Тийм ч учраас хэдэн зуун жил зэвсэг бариагүй малчид 1921 оны хувьсгалын хатуу хүтүүг үүрсэн эх орончид байв.

3. Карьеристууд: Энэ бүлэгт цэрэгт элсэхээсээ өмнө эрхэлж байсан ажил хөдөлмөрөө, цэргээс халагдсанаа дараа сольсон хүмүүсийг оруулсан. Тэд өөрсдодөө тохиосон боломжийг дуртайяа ашигласан. Карьеристуудын ихэнхи нь орон нутагтаа эргэж очсон бол бас хүрээнд үлдэж шинэ ажил мэргэжлийг эзэмшсэн хүмүүс ч бий. Доор өгүүлэх жишээ бол журамт цэрэгт элссэнээр айлын зарцаас захиргааны ажилтан болж шилжсэн хүний нэг юм.

...15 наснаас нутгийн Жанцан гэдэг баян айлд зарагдаж байгаад 1921 онд журамт цэрэгт элсэн орж Хиагтыг эзлэн авах байлдаанд оролцжээ. 1921-1930 онд засаг захиргааны байгууллагад сонгуулийн ажил хийж байгаад 1930 оноос хойш малын ажилтай байжээ. (Д.Дэндэв, Ардын журамт цэргийн дуртгалууд., 1985)

Хагас өнчин, хөгшин эх ба өөрийгөө тэжээх гэж биеийн хүчийг үнэлж амьдардаг байсан партизан маань хувьсгалын дараа цэргийн албаар дамжуулж олон нийтийн байгууллагад амжилттай ажиллаж намд хүртэл элсжээ.

1921 оны партизан, Хувьсгалаас хойш цэргийн алба орон нутгийн засаг захиргаа, олон нийтийн байгууллагуудад удаан жил ажиллаж байжээ. 1932 онд МАХН-ын гишүүнд элсжээ. (Т.Ёндон, Ардын журамт цэргийн дуртгалууд., 1985)

Ийнхүү алба хаасан партизанууд суга өсөж, орон нутагт харихдаа өөрийн байр суурийг олж чадаж байв. Мэдээж тэд бол орон нутагтаа баатрууд, эх орноо харийн түрэмгийлэгчдээс хамгаалах хүндтэй үүргийг гүйцэтгэсэн эр зоригтнууд, цаг төрийн байдлыг ч тэд хэнээс ч илүүтэй барагцаалж байлаа. Ардын нам, улаан орос, хувьсгалчид гээд жирийн хүмүүсийн хувьд үл ойлгох нэр томъёог тэд бүгдийг нь үзэж харсан. Цэргийн албыг улируулан хашиж

III МОНГОЛЫН ОЙРХИ ТҮҮХИЙН АСУУДЛУУД

улмаар орон нутагтаа эргэж ирэн хариуцлагатай албанд тохоогдсон хүний нэг жишээг доор өгүүлнэ.

1921 оны партизан, ...улмаар ардын цэргийн албыг улируулан хаажээ. 1946 оноос 1963 он хүртэл засаг захиргааны байгууллагад ажиллаж байгаад нэгдлийн гишүүн болжээ. 1926 онд МАХН-ын гишүүнд элсжээ. (Б.Намсрай., Ардын журамт цэргийн дуртгалууд., 1985)

Гэвч хувьсгалын дараах нийгмийн реформ мэдлэг чадвартай боловсон хүчний шаардлаж байжээ. Тиймээс партизанууд маань цаг үеийн шаардлагад нийцэж сурах хэрэгтэй болно. Лав 37 хүн буюу 4.0 хувь нь сургуульд суралцсан аж. Шинэчлэлийн үзэл санааг тээгч гол институт нь сургууль бөгөөд сурах нь тухайн хувь хүний өөрийн амьдралдаа хийсэн хамгийн том өөрчлөлтийн нэг байсан, тэр ч хэрээрээ нийгэмд хөгжил дэвшил авчирч байсан нь эргэлзээгүй. Учир нь хувьсгалын дараа шинэ засгийн бодлого, үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд зэвсэг барин тэмцэгчдээс илүүтэй уншиж бичиж чаддаг, үзэл суртал, бодлогыг ойлгодог, өрнөдийн соёлын наад захын элементүүдийг эзэмшсэн шинэ цагийн мэргэжилтнүүд ус агаар шиг хэрэгцээтэй байв. Тиймээс яаравчлан байгуулсан сургуулиудыг төгсөгчид бүгд л тодорхой хугацааны дараа төр засаг, намын удирдлагад гарч ирсэн нь санамсаргүй зүйл байсангүй. Ингэхдээ юуны түрүүнд цэргийн сургуулийг эхэлж байгуулжээ.

Нийслэл хүрээнд 1922 онд Их даргын сургуулийг байгуулахаар зарлал гаргаж цэргүүдийг татан авав. Их даргын сургуульд орж суралцан хэдэн сар болов. (Ц.Дугар., Ардын журамт цэргийн дуртгалууд., 1985)

Богд хааны цэргийг бодвол журамт цэргийн нөхцөл олон талаараа дээшилсэн бололтой. Тиймээс цэргийн чиглэлээрээ сурах нь мэдлэг боловсролтой болохоос гадна сурч дассан салбартаа ажиллах аятай боломжийг бий болгож байв. Мөн журамт цэрэг нь шинэ цагийн боловсон хүчний баталгаатай эх сурвалж байсан нь эргэлзээгүй. Тиймээс олон хүн эндээс насан туршдаа ажиллах өөрийн салбарыг ч олж авчээ. Үүний нэг сонирхолтой жишээ бол 1920-иод оны үед жолооч гэдэг эрхэм хүндтэй мэргэжил эзэмшсэн хүн юм.

“Мөнгө, төмрийн дархан хийж чадах хүн байна уу? гэж асуув. Иймд Доржпалам би байна гэв. Мөн манай сумангийн Батнасан би дархан хүн гэв. Тэр өдрийн орой бид хоёрыг Цэргийн яамны Маньбадар гэдэг хүн дээр хүргүүлэв. Маньбадар Цэргийн чийчааны сургууль хийнэ гэв. Ингэхэд миний бие дотроо их баярлаж байлаа. Ингээд би чийчааны сургууль хийж 12 (1922) оны эцсээр форд зэрэг машиныг хөдөлгөх боллоо. Үүнээс хойш би жолоочийн ажлыг хийх болсон юм. (Б.Доржпалам., Ардын журамт цэргийн дуртгалууд., 1985)

Нийтдээ 40 орчим хүн цэргийн албандаа үлдэж, шинээр татагдсан цэргийг сургахаас эхлээд шинэ тулгар улсын цэргийн яамны сайд гэдэг хүндтэй албан тушаалыг эрхлэнэ. Цэргийн сургуулийн эхлэл болсон “Түр курс”-ын тухай архивын баримтад

...“4 аймгийн 86 хошуу, шавийн 2 хошуу тус бүрээс бичиг үсэг сайн мэдэх чадварлаг хүн нижгээдийг гаргаж түр курст суралцуулахаар цэргийн яаманд ирүүлэх” (Ч.Ганбаатар, 1991)

гэж бичжээ. Улмаар цэргийн даргын анхны сургууль байгуулж шаардлагатай боловсон хүчнийг бэлтгэж гаргасан байна.

1921 оны 4-р сард Д.Сүхбаатарын санаачилгаар морин бригадын дэргэд цэргийн даргын анхны сургууль байгуулагджээ. 1921 оны 8-р сард уг сургуулийг өргөтгөх тухай Д.Сүхбаатарын тушаал гарч мөн оны 10-р сард морин цэрэг, улс төрийн гэсэн 2 курстэй, “Ардын цэргийн даргын сургууль” нэртэй 6 сарын хугацаатай эл сургууль 90 хүнийг бүртгэн авч хичээлээ эхэлсэн байна. (Ч.Ганбаатар, 1991)

Ингэж сургууль төгссөн хүмүүс өөртөө шинээр олон боломжийг нээсэн гэдгээ тухайн үедээ сайн ухаараагүй ч байж мэднэ.

III МОНГОЛЫН ОЙРХИ ТҮҮХИЙН АСУУДЛУУД

1921 оны партизан, хотод үлдэж улмаар нэгдүгээр морин хороонд салааны даргын үүргийг гүйцэтгэж эхэлсэн ба даргын сургуульд орж 1922 оны эцсээр төгсгөв. Сумын дивизийн дарга бага даргын сургуулийн захирал зэрэг ажлыг 1933 он хүртэл гүйцэтгэжээ. (Ц.Дэндэв., Ардын журамт цэргийн дуртгалууд., 1985)

Мөн орост цэргийн мэргэжилтнүүдийг сургах ажлыг санаачлан хэрэгжүүлсэн нь цэргийн салбарынхны хувьд томоохон боломж байжээ.

1921 оны намар Д.Сүхбаатарын хүсэлтээр Равдан, Мончгоо, Бямба, Аюушжав нарыг Эрхүү хотын улаан цэргийн даргын курст суралцуулснаар ЗОУ-д цэргийн дарга нарыг сургаж бэлтгэх эхлэл тавигджээ. (Г.Мягмарсамбуу, 2001)

Ингэж ядуу айлын зарцаас армийн ахлах даргын албан тушаал хүртэл дэвшиж чадаж байсан нь тухайн нийгэмд том өөрчлөлт орж байсныг харуулж байна.

Миний бие туйлаас ядуу ангийн туйлын хоосон хүний хүү бөгөөд бага настай байхад эцэг эх нас нөгчсөн тул би айлын зарц болж мал адуулан, хар бор ажил хийж явсаар 15 нас хүрсэн. ...Хувьсгалын дараа Цэргийн яам болон Москва хотноо Монголын Элчин сайдын яаманд албан хааж 1928 онд Алтанбулагт тээх нэвтрүүлэхийн салбарын даргын ажлыг 7 сар хааж байгаад ЗХУ-д Тверийн морин цэргийн сургуульд сурагч, хэлмэрч болж уг сургуулийг төгсгөж ирснээс хойш цэргийн газар дунд, дээд, ахлах тушаалын даргын албыг хааж байжээ. (Б.Өлзийханд., Ардын журамт цэргийн дуртгалууд., 1985)

Дайны дараа үргэжлүүлэн цэргийн алба хааж байсан тэд монголд анх удаа орж ирж байсан онгоцны нисгэгч болж Монгол Улсын баатар гэдэг Алдрыг хүртэх хувь ч бас тохиосон.

1921 онд Ардын журамт цэрэгт элсэн орсон...улмаар цэргийн албыг улиран хааж 1924 онд Хуягт тэрэгний хороонд шилжин, Хуягт машины жолооч, байлдааны машины дарга болжээ. 1929 оноос ЗХУ-ын Оренбург хотод нисэх онгоцны техникчийн ба 1933 онд Улаанбаатар хотод нисэгчийн сургуулийг тус тус төгсөөд ...нисэгчээс Нисэх отрядын дарга хүртэл дэвшин ажиллажээ. (Д.Дэмбэрэл., Ардын журамт цэргийн дуртгалууд., 1985)

Судалгаагаар журамт цэргүүдээс алба үргэлжлүүлэн хааж жанжин 1, генерал 1, дунд тушаалын дарга 6, ангийн дарга 1, улс төрийн ажилтан 3, дэд жанжин 1, хороон дарга 7, нисгэгч 1, зөвлөгч 1, нисэх отрядын дарга 1, дээд тушаалын дарга 1, дивизийн дарга 3, суманийн дарга 1, штабын дарга 1, цэргийн яамны 3-р газрын дарга 1, төлөөлөгч 1, нийтдээ 40 орчим хүн цэргийн салбартаа албан тушаал дэвшжээ. Эдгээр хүмүүсийн цаашдын хувь заяа нь хэрхсэн бэ? Үүний хариулт тун ээдрээтэй юм. Хувьсгалын өмнөхтэй харьцуулбал баялаг туршлагатай, хат суусан, цэргийн салбарын нэр хүнд бусад салбараас давж гарав. Тийм ч учраас цэргийн салбараас бусад яамдын боловсон хүчин элбэгдэх нь болсон нь тийм ч гайхмаар зүйл биш юм. Ямартаа ч журамт цэргүүдийг цэрэгт элсэхийн өмнөх үе ба цэргээс халагдсаны дараах үеийн амьдралыг харьцуулахад нийт партизануудын 417 хүн буюу 44.9 хувь нь цэрэгт явснаар социал статус нь дээшилсэн гэсэн дүн гарчээ.

4. Шинэ элит: үүсэл ба гараа. Хувьсгалын дараа хувьсгалчид шинэ элит болон төлөвшихийн тулд нийгэм дэх хамжлагат ёс, язгуур гарлыг халж шинэчлэлийг эхлүүлэх ёстой байв. Судалгаанаас үзэхэд хувьсгалчдын үзэл бодол тун ч зөрчилтэй, хоёрдмол байсан гэдэг нь анзаарагддаг. Энэ нь нэг талаас түрэмгийлэгчдийг цэвэрлээд шашин төрөө мандуулна гэсэн чин хүсэл, нөгөө талаас дэлхийн хүн төрөлхтөний хөгжлийн замаар явахын тулд нийгэмд хийх реформын зорилт хоёрын парадокс юм. Ямар боловч нийгмийн эрс өөрчлөлт болгон шинэ элит, лидерийг төрүүлдэг бөгөөд тэр хүмүүсийн эх сурвалж нь партизанууд байсангэдэг нь эргэлзээгүй. Ерөнхийд нь зураглавал шинэ цагийн элит, лидерүүдийн нийтлэг дүр төрх нь санаачлага ба эрмэлзэл, нам эвлэлийн гишүүнчлэл, сургууль ба боловсрол зэргээрээ бусдаас ялгарч байжээ.

5. Санаачлага ба эрмэлзлэл: Партизануудын намтар, дурсамжинд хийсэн судалгаанд нийтлэг ажиглагдсан зүйл бол хүний амжилт, ирээдүй нь тухайн хүний гарт байдаг тухай юм. Тодруулбал партизануудын ирээдүй өөрсдийнх нь санаачлага ба эрмэлзлэлээс шууд шалтгаалж байв. Журамт цэрэгт элссэн нь гарааны нөхцлийг нь тэгшитгэж өгсөн бөгөөд өнчин, зарц, хар бор ажил хийдэг олон хүмүүс бусадтай ижил тавцангаас гараагаа эхлэх боломжийг олгосон. Мэдээж үүнээс цааш тэдний өмнөх амьдралаа өөрчлөх, эрсдэл хийж шинийг эрэлхийлэх чадвар, чармайлт зэргээрээ бусдаасаа ялгагдана. Хамгийн гол шалгуур бол алба хаахдаа өөрсдийн санаачлагатай, идэвхтэй, дарга нарын өгсөн үүрэг даалгаврыг сайн гүйцэтгэж итгэлийг хүлээж байсан хүмүүс шинэ цагийн элит, лидерүүд болох нэр дэвшигчдийн жагсаалтанд дэвшин орж байжээ.

6. Эвлэл ба Нам: Шинээр үүсэн бий болох улс төрийн институцийн гол цөмийг орон нутгийн сонгууль, нам мөн МХЗЭ, МҮЭ зэрэг институт бүрдүүлэх учиртай. Тиймээс партизануудаас 9 хүн МХЗЭ-д элссэн бөгөөд энэ байгууллага нь хувьсгалын дараах 10 гаруй жилийн туршид их нөлөөтэй, бараг идэвхтэй сөрөг хүчин байснаа улмаар намын бэлтгэл хүчин болж хувирчээ. Партизан Х.Чойбалсан, Ж.Баваасан, Г.Гүрсэд, Б.Доржпалам, Ж.Дэжид-Осор зэрэг хүмүүс “Бошгыг халах залуучуудын эвлэл” нэртэйгээр санаачлан байгуулж удирдаж байжээ. (З.Лонжид, Г.Дашням, 1996)

1921 оны партизан. ...Ардын нам, түр засгийн газар нийслэл Хүрээг чөлөөлөн авч засаг төрийг тогтоон тохируулсан даруй хувьсгалт залуучуудын эвлэлийг анх байгуулах хэрэгт оролцож зохион байгуулж явсны дээр Буянгэмх нарын хамт Дорно дахины ард түмний анхдугаар хуралд оролцов. 1902 онд төрсөн, 1921 оны партизан 1945 оны чөлөөлөх дайнд оролцжээ. (Ц.Гомбожав, Ардын журамт цэргийн дуртгалууд, 1982)

Чухамдаа олон залуучууд эхлээд эвлэлд элсээд удалгүй намд элсдэг замнал эндээс эхтэй байх юм.

Намайг нутаг буцаж ирсний дараа 1921 оны сүүлч, 1922 оны эхээр Амгалан, хар нүдэн Тунсаг нар Улиастайд ирж нам, эвлэлийн байгууллагыг зохион байгуулсан юм. Би 1922 онд Улиастай дахь Хувьсгалт залуучуудын сурган хүмүүжүүлэх эвлэлийн үүрийн гишүүнд сайн дураараа элсэж 1922 оноос 24 он хүртэл эвлэлээр сурч хүмүүжиж байгаад Улиастайн энгэрийн хашаанд Хувьсгалт намын 14 дүгээр үүрт сайн дураар элсэн орж намаар хүмүүжиж эхэлсэн юм. (С.Жамсран, Ардын журамт цэргийн дуртгалууд, 1985)

Баримт түшвэл партизануудын хувьд цаашид шинээр байгуулагдсан ардын намд элсэхэд бэрхшээлтэй зүйл байгаагүй. Гэвч үнэндээ партизанууд хэзээ ч ардын намд элсэхийг зорилгоо болгож байсангүй. Судалгаанд хамрагдсан нийт партизануудаас 150 хүн буюу 16.5 хувийн МАХН-д элссэн эсэх талаархи мэдээлэл олдоогүй болно. Таамаглавал өдгөөр хүмүүс намын гишүүн биш байсан болов уу, учир нь хэрвээ гишүүн байсан бол дурдатгалд заавал оруулдаг, бахархууштай зүйлийн нэг мөн. Гэхдээ хэлмэгдсэн бол бас л намын гишүүн байсан ч дурдахгүй өнгөрдөг. Ер нь дурдатгал бичсэн цаг хугацаа тухайн үеийн үзэл суртал зэргийг анхаарах учиртай. Тэгэхлээр намын гишүүний тоог ханатай гэж үзэж болно. Доор хэрхэн ардын намд хэрхэн элссэн тухай нэгэн баримтыг сонирхоё. Ямар боловч батлан даалтгүй, сайн дураар нь элсүүлж байсныг доорх жишээ харуулж байна.

Нэг өдөр жанжин ирж, намд элсэх хүсэлтэй хүн саналаа өг! гэж уриалав. Тэгэхэд би санал өгч намд элсэж билээ. Тэр үед намд элсэхэд даалт баталгаа гаргалтгүйгээр зөвхөн нэр бичиж аваад элсүүлж байсан билээ. Энэ нь цэргийн газар анх удаа намын байгууллага үүсч байсан хэрэг. Намд элсээд хэд хоносны дараа цэргийн дарга нарын анхдугаар сургууль байгуулав. Миний бие жараад нөхдийн хамт уул сургуульд оров. 1922 оны эцсээр төгсөв. Би онцсайн дүнтэй төгсөж салааны дарга болов. Дараа нь сумангийн суртлын сургагч тохоогдов. Хоёр жилийн дараа

III МОНГОЛЫН ОЙРХИ ТҮҮХИЙН АСУУДЛУУД

Дотоодын хамгаалах газрын тусгай сумангийн комиссараар томилогдов. (Д.Магсар., Ардын журамт цэргийн дуртгалууд., 1985)

Тэгэхлээр намд элссэн хүмүүс партизанууд дунд хэдэн хувийг эзэлж байгаа гэдэг нь ихээхэн сонирхолтой баримт болно. Үүнийг он оноор харьцуулан гаргавал бүр сонирхолтой дүр зураг гарах нь дамжиггүй. Чингэхүл 1921 онд багтаж 21 хүн намын гишүүн болсноор шинэ зам, шинэ амьдралыг сонгожээ. Одоо эргэлзээтэй асуулт гарч ирнэ. Яагаад 1921 онд алдар цуугаа мандуулаад байсан намд партизануудын дөнгөж 2 хүрэхгүй хувь нь элсэв? Эсвэл арми нь илүү алдартай, намыг хэн ч тоодоггүй байв уу? Энэ хэсэгт баримтууд зөрчилдөж эхэлнэ. Намд чөлөөтэй, сайн, дураараа элсэж байжээ гэсэн баримтыг О.Латтимор авгай үгүйсгэсэн байх юм. Тэрээр

Эдгээр шигшмэл нөхдөөс тун цөөхөн нь сүүлдээ өндөр албан тушаалд хүрсэн явдал ийм тооны учрыг бүр тодотгож өгч байна. Монголын хувьсгал анхнаасаа коммунист зохион байгуулалтын зарчмаар явагдсаныг жирийн партизануудын дуртгал харуулж байна. Түүний цөмийг мэргэжлийн хувьсгалчид бүрдүүлж байсан бөгөөд тэд зөв улс төрийн байр суурь үгүй бол зоригтой эх оронч цэргүүдийг хүртэл намд элсүүлэн авдаггүй байжээ. (О.Латтимор, Нүүдэлчид ба хувьсгалчид, 1994)

гэж дүгнэсэн байх юм. Уул санааг задалбал нэгдүгээрт, хувьсгалчид анхнаасаа коммунист зохион байгуулалттай байсан, хоёрдугаарт, хувьсгалчид партизануудыг дэвшүүлэн өөрсдийн эгнээнд элсүүлэхдээ ийм зарчмыг баримталдаг байсан, гуравдугаарт эр зоригтой, эх оронч цэргүүд хувьсгалчдын эгнээнд элсэхийг хүссэн ч элсүүлж авдаггүй байсан, дөрөвдүгээрт, тийм учраас шигшмэл нөхдөөс тун цөөхөн нь сүүлдээ өндөр албан тушаалд хүрчээ гэсэн утгыг илэрхийлнэ. Бидний судалгааны үр дүн дээрхээс зарчмын өөр байр суурийг илэрхийлэхэд хүргэж байгаа юм. Яагаад? Юуны түрүүнд ардын намынхан дунд мэргэжлийн хувьсгалч гэхээр улайрсан большевик, үзэл суртлын фанатууд байгаагүй. Энэ тухай Баабар

Нууц байгууллагыг хооронд нь ялгахын тулд хамрагдаж буй гишүүнээр нь түшмэдийн, ноёдын, ардын гэж ялгасан бололтой. Харин аль нам нь Богдыг тойрон хүрээлсэн, түүнп дулдуйдсан бүлэглэл байсан ба Хятадын гараас гарч шашин төрөө мандуулна гэсэн ижил зорилго чиглэлтэй байв. (Баабар, 2006)

гэсэн юм. Тэгэхээр анхнаасаа коммунист зохион байгуулалттай байгаагүй, хоёрдугаарт партизануудыг дэвшүүлэхдээ коммунист зарчмыг биш харин тэдний өөрсдийн нь идэвх санаачлага, ажил үүрэг гүйцэтгэх ур чадварыг нь харгалздаг байсан, гуравдугаарт намд элсэх нь 1921 оны үед харин ч чөлөөтэй байсан гагцхүү партизануудын хувьд намд элсэх нь тийм ч их хүсүүштэй зүйл биш байсан учраас тоодоггүй байсан, дөрөвдүгээрт, хувьсгалын дараа партизанууд нам төрийн удирдлагын удирдагч нарын 25 орчим хувийг, цэргийн салбарын дээд удирдлагын бараг 80 хувийг эзэлж байсан зэрэг баримт нь дээрх дүгнэлтийг эргэлзэхэд хүргэж байгаа юм.

Гэхдээ яваандаа намд элсэхээс цаашид шинэ цагийн улс төрд амжилт олох нь хамаарна. 1922-1924 онд нийт партизануудаас 20 хүн л намд элсчээ. Бүр сүүлд буюу хувьсгалын дараа, Богд гэгээн нас барж, шинэ үндсэн хууль баталж, хамжлагын харилцааг халсны дараа 1925-1928 онд 17 хүн, зүүнтний нугалаа гарч Монгол орон өөрийн хөгжлийн зам мөрөөс гажуудсан 1929-1932 онд 5 хүн, 1941-1943 онд 2 хүн тус тус элсчээ. Харин 1943 оноос хойш 9 хүнээр нэмэгджээ. Үүнийг жил тутам өсөн нэмэгдэж байсан МАХН-ын нийт гишүүдтэй хүснэгтээр харьцуулан харуулбал дараах сонирхолтой хүснэгт гарна.

Эх сурвалж: (Монгол ардын хувьсгалт намын түүхэн замнал, 1995)
(МАХН Их, Бага хурал, Тов Хорооны Бүгд хурлуудын тогтоол шийдвэр, 1956)

МАХН-д элссэн он	МАХН-д элссэн журамт цэргийн тоо	Нийт партизануудад МАХН-ын гишүүний	МАН-ын гишүүн, орлогчийн нийт тоо	МАН-ын нийт гишүүдэд партизан
---------------------	-------------------------------------	--	--------------------------------------	----------------------------------

III МОНГОЛЫН ОЙРХИ ТҮҮХИЙН АСУУДЛУУД

			ЭЗЛЭХ ХУВЬ		ГИШҮҮДИЙН ЭЗЛЭХ ХУВЬ
1	1921	21	2.3	150	14
2	1922	21+8(29)	0.9	225	12.8
3	1923	21+8+5(34)	0.5	769	4.4
4	1924	21+8+5+7(41)	0.8	3000	1.3
5	1925	21+8+5+7+7(48)	0.8	4639	1.03
6	1926	21+8+5+7+7+4(52)	0.4	5804	0.8
7	1927	21+8+5+7+7+4+3(55)	0.3	11619	0.4
8	1928	21+8+5+7+7+4+3+3(58)	0.3	13896	0.4
9	1929	21+8+5+7+7+4+3+3+3(61)	0.3	15810	0.3
10	1930	21+8+5+7+7+4+3+3+3+2(63)	0.2	12019	0.5
11	1932-43	21+8+5+7+7+4+3+3+3+2+3(66)	0.3	14569	0.4
12	Хэзээ элссэн нь тодорхойгүй	21+8+5+7+7+4+3+3+3+2+3+8(74)	0.8	--	--
13	Нийт	74	7.9	14569	0.4

Нийт партизануудаас МАН-д элссэн хүмүүсийн тоо 74-т л хүрч байгаа бөгөөд энэ нь нийт партизануудын 8 хувиас хэтрэхгүй. 1921 оны байдлаар намын гишүүн партизануудын тоо нь дөнгөж 21 хүн байсан бөгөөд энэ нь нийт партизануудын 2.3 хувь, харин МАН-ын нийт гишүүдийн дөнгөж 14 хувьтай тэнцэж байна. Нийт намын гишүүдэд партизануудын эзлэх хувь 1922 он гэхэд 12 хувь, 1923 он гэхэд 4.4 хувь, улмаар 1924 онд 1.3 хувьтай болж, 1925-1943 он хүртэл 1.03 хувиас 0.4 хувь хүрч багасжээ. Аль ч тооцоогоор партизануудаас цөөхөн хүн намд элссэн нь сонирхолтой бөгөөд яаж ч дарахын аргагүй ийм баримтыг хэлэхээс болгоомжилж журамт цэргийн эмхэтгэлд дурдаагүй бололтой. Тэгэхлээр партизанууд бол эхнээсээ эх орончид, үндэсний тусгаар тогтнолын төлөөх хөдөлгөөнд нэгдсэн жирийн малчид байсан гэдгийг энэ баримт харуулж байна. Түүнээс бус марксист утга зохиолд гуйвуулсан шиг мэргэжлийн хувьсгалчид, дарлагдсан анги, большевикууд байгаагүй, хойшид ч гэсэн энэ хэвээрээ үлджээ.

7. Сургууль ба боловсрол. Мэдээж шинэ цагийн лидерүүдэд тавигдах шаардлага, боловсрол мэдлэг өндөр байх шаардлагатай байв. Цэргийн даргын сургууль, бичиг үсэг сурах курс зэрэг бол үүний эхлэл болохоос бүрэн хангалттай биш. Тэгээд ч Монголд анх удаа барууны стандартанд нийцсэн сургуулиудыг шинээр байгуулах ажлыг эхлүүлнэ. Юуны түрүүнд байгуулагдсан Намын төв сургуульд тэд суралцаж байв.

Төв аймгийн харьяат Сүхбаатарын цэрэг явж Ивцэг Галттай зэрэг газраар цагаантантай байлдахад оролцож яваад улмаар цэргийн албан хааж яваад 1925 онд Намын сургуулийг төгсч дахин цэрэгт очиж дунд ахлах тушаалтай Завхан аймгийн цэргийн хэлтсийн дарга зэрэг ажлыг хийж явжээ. (Г.Буниабазар, Ардын журамт цэргийн дуртгалууд., 1985)

Цаашилбал өөр олон залуучуудтай хамт Эрхүүгийн рафбак, Москва дахь КУТВ, Тверийн морин цэргийн сургуулийг төгсөнө.

1921 онд Монголын партизан цэрэгт орж, хятадын түрэмгийлэн эзлэгчдээс тус орныг чөлөөлөх хувьсгалт тэмцэлд биеэр оролцож 1923-1928 онд Дорно Дахины их сургуульд (КУТВ) суралцаж хожим нь КУТВ-д монгол оюутны багш Монголын анхны төмөр замчдыг бэлтгэх курсийн захирлаар ажиллаж байжээ.

Ингэж анхны боломж гарангуут эхний хүүхдүүдийг Оросд сургаж эхэлсэн бөгөөд Монголд худалдааны техникум, санхүүгийн сургууль зэргийг яаралтай байгуулав. Чухамдаа эдгээр сургуулиудаас Монголыг авч явах дараагийн үе төрөх болно. Судалгаанаас үзэхэд хувьсгалын дараа партизануудаас 78 хүн буюу 8.4 хувь хувьсгалын дараа ямар нэгэн байдлаар удирдах ажил хийж социал статус нь дээшилсэн бөгөөд өмнөх засгийн үед хүрч чадахааргүй өндөрлөгт хүрчээ. Судлаач Миллс америкийн нийгмийн амьдралыг улс төр, эдийн засаг,

III МОНГОЛЫН ОЙРХИ ТҮҮХИЙН АСУУДЛУУД

цэргийн хүрээнд төвлөрлийн үйл явц болсон гэж нотолдог (С.В, 1956). Дээрх гурван бүлгийн төлөөлөгчид нь засаглалын нарийн систем болон бүрэлдэж, голдуу нийгмийн нэг орчноос гаралтай, адилхан үзэл бодолтой, нийтлэг ашиг сонирхолтой байхаас гадна бие биетэйгээ танил байх нь цөөнгүй (Э.Гидденс, 2007). Социологич Х.Гүндсамбуу номенклатурчдын бүтцийг намын, төрийн, техникийн хүнд сурталтнууд гэж гурав хуваан үзсэн (Х.Гүндсамбуу, 2002). Зохиогч өмнөх өгүүлэлдээ Монголын УТГ гишүүн ба орлогч гишүүн, НБД нарыг партократууд, парто-технократууд, парто-демократууд гэсэн гурван үндсэн бүлэгт хуваан үзэж судалсан¹. Тиймээс дээрх аргазүйг ерөнхийд нь баримтлан журамт цэргээс төрсөн лидерүүдийг цэргийнхэн, нам төрийн удирдагчид, технократууд гэсэн гурван хэсэгт хуваан үзэж болох юм.

7. Цэргийнхэн: Журамт цэргүүдээс цэргийн салбарт олон дарга нар төржээ. Цэргийн салбарт 1921-1950 он дуустал өндөр албан тушаал хашсан хүмүүсийг цэргийн түүхч С.Гангаанямын (С.Гангааням, 1991) гаргасан баримтанд тооцоо хийж үзэхэд дараах байдалтай байна.

	Категори	Он сар,	Давхардсан эсэх	Партизаныг + тэмдэгээр тэмдэглэв.	Нас барсан он	Хэлмэгдсэн эсэх
А.	Бүх цэргийн зовлөлийн тэргүүлэгчид	4		2		
1	Рэнцэнгийн Элбэгдорж	1921-1925		+	1937	++
2	Нваандоржийн Жадамба	1925-1929			1939	++
3	Лувсангийн Шархүү	1929-1930			1937	++
4	Гэлэгдоржийн Дэмид	1930-1932		+	1937	++
Б.	Бүх цэргийн жанжин	6		6		
5	Дамдингийн Сүхбаатар	1921-1923		+	1924	
6	Солийн Данзан	1923-1924		+	1924	++
7	Хорлоогийн Чойбалсан	1924-1929		+	1952	+
8	Өлзийтийн Чулуун	1929-1930		+	1942	++
9	Гэлэгдоржийн Дэмид	1932-1937	+		1967	+
10	Хорлоогийн Чойбалсан	1937-1952	+			
В.	Цэргийн яамны сайд нар	7		6		
11	Дамдингийн Сүхбаатар	1921-1922	+			
12	Сандагдоржийн Магсаржав	1922-1927		+	1927	
13	Сүрэнгийн Дэндэв	1927-1929		+	1938	++
14	Сандагсүрэн	1929-1929				?
15	Ламхүүгийн Дарьжав	1929-1930		+	1937	++
16	Гэлэгдоржийн Дэмид	1932-1937	+			
17	Хорлоогийн Чойбалсан	1937-1950	+			
Г.	Цэргийн явдлын яамны сайд, бүх цэргийн жанжны орлогчид	14		8		
18	Лаварын Сумьяа	1921-1921		+	1935	+
19	Хорлоогийн Чойбалсан	1921-1922	+			
20	Сандагдоржийн Магсаржав	1921-1922	+		1927	
21	Далантайн Өлзийбат	1932-1934			1937	++
22	Төмөрийн Дашзэвэг	1932-1933		+	1937	++
23	Дуламсүрэнгийн Дашчарви (нэгдүгээр орлогч)	1934-1936		+	1936	+
24	Гончигийн Самбуу (хоёрдугаар орлогч)	1934-1936		+	1937	++

¹ Ч.Тамир. УЛС ТӨРИЙН ТОВЧООНЫ ГИШҮҮДИЙН ХЭВ МАЯГ, СОЦИАЛ ТӨРХ (1940-1990 он) (Политологи сэтгүүл. 2009 оны № 297 (50) IV дугаар. МУИС)

III МОНГОЛЫН ОЙРХИ ТҮҮХИЙН АСУУДЛУУД

25	Лхамхүүгийн Дарьзав (нэгдүгээр орлогч)	1936-1937	+		1937	+
26	Гэндэнжавын Лут-Очир (хоёрдугаар орлогч)	1936-1937			1937	++
27	Готовын Дамба (нэгдүгээр орлогч)	1937-1939		+	1941	++
28	Цэрэнжавын Лувсандоной	1939-1939			1941	++
29	Жамьянгийн Лхагвасүрэн	1939-1948				+
30	Юмжаагийн Цэдэнбал	1941-1945				
31	Цэдэнгийн Жанчив	1948-1950				
	Нийт 31 хүн			Партизан 22	Хэлмэг-нас	
	Давхардаагүй 23			Партизан 14		

Цэргийн өндөр албан тушаалтан буюу бүх цэргийн зөвлөлийн тэргүүлэгч, бүх цэргийн жанжин, цэргийн яамны сайд, цэргийн явдлын яамны сайд, бүх цэргийн жанжны орлогч зэрэг албан тушаалыг хашиж байсан хүний тоо давхардсан байдлаар 31 хүн байгаагаас партизанууд 22 буюу 71 орчим хувийг эзэлж байна. Давхардаагүй тоогоор 23 хүнээс 14 нь партизан байсан гэж тооцож үзвэл 61 хувийг эзэлж байна. Ялангуяа цэргийн яамны сайд 7 хүний 6-г нь, бүх цэргийн жанжин 6 хүн бүгдээрээ партизанууд байна. Мөн үүнээс гадна генерал 1 хүн, дээд тушаалын дарга 1 хүн, девизийн дарга 3 хүн нийтдээ 5 хүн нэмэгдэнэ. Тухайлбал цэргийн яамны сайд асан С.Дэндэвийн товч намтрыг сонирхуулья.

1921 оны партизан, 1922 онд Бүх цэргийн сурган боловсруулах газрын бичээч, 1923 онд МХЗЭ-ийн ТХ-ны тэргүүлэгч гишүүн бөгөөд нарийн бичгийн дарга байжээ. 1924 онд цэрэг ардыг сурган боловсруулах газар нарийн бичгийн даргаар дэвшин ажиллаж, ...1925 онд сурган боловсруулах газрын хэлтсийн дарга, 1927 онд БНМАУ-ын Цэргийн яамны сайдаар сонгогдон ажиллаж Бүх цэргийн зөвлөлийн гишүүн болжээ. (С.Дэндэв., Ардын журамт цэргийн дуртгалууд., 1985)

Цөөнгүй нь цэргийн салбарынхаа анхны мэргэжлийн армийн мэргэжилтэн болох хувь заяа тохиосон.

1921 оны партизан, Шинэ буюу байлдааны төгсгөлөөр ирсэн бидний цэргүүдийг Ховд хязгаарыг хамгаалах байнгын цэргийн хороо байгуулах үндэс суурь болгон үлдээв. Би, тэр цэргийн тоонд орж үлдсэн билээ. 1922 онд Бүх цэргийн ерөнхий сургуульд суралцан нэгдүгээр морин бригадалд салааны даргаар томилогдон ажиллаж улмаар ЗХУ-ын Твер хотноо морин цэргийн дунд сургууль, мөн Москва хотноо Фрунзийн нэрэмжит цэргийн академид тус тус суралцан төгсгөсөн байна. Монгол ардын хувьсгалт цэрэгт цэргийн дивизийг командлан захирагч цолтой явсан байна. (Д.Жамьянжав., Ардын журамт цэргийн дуртгалууд., 1985)

Улмаар өмнө өгүүлсэнчлэн цэргийн салбараас дамжин шүүх яам, тэр ч бүү хэл гадаад харилцааны салбарт хүртэл өндөр албан тушаалд томилогдож байв.

1921 оны партизан, 1924 оноос цэргийн албанд дахин мордож, Бүх цэргийн сурган боловсруулах газар, хэлтсийн дарга цэргийн шүүх коллегийн дарга, цэргийн ба улсын прокурорын дарга, Шүүх яамны сайд, БНМАУ-аас ЗХУ-д суух Онц бөгөөд бүрэн эрхт элчин сайд зэрэг чухал албан үүрэг гүйцэтгэж явжээ. (Ж.Дэндэв., Ардын журамт цэргийн дуртгалууд., 1985)

Хувьсгалын дараа цэргийн лидерүүдийн хувь заяа өөр өөрөөр төгссөн. Эдгээр хүмүүсээс 23 хүнээс 17 буюу 73 орчим хувь нь ямар нэгэн байдлаар хэлмэгдсэн бол 13 хүн буюу 56 хувь нь буудуулж өөрсдийн санаачилсан хувьсгалынхаа шуурганд нэрвэгджээ. Харин Г.Бумцэнд тэргүүтэй цөөхөн хүн насан эцэслэлтээ нэр хүнд, алдар гавьяаг эдэлжээ.

8. Нам, төрийн зүтгэлтнүүд: Партизануудаас төрсөн дараагийн бүлэг нь нам, төрийн зүтгэлтнүүд юм. Түүхч Ч.Болдбаатарын “XX зууны Монголын төрийн зүтгэлтнүүд” (Ч.Болдбаатар, 2004) номонд багтсан 100 орчим хүмүүсээс шүүж үзэхэд 24 хүн партизанаас

III МОНГОЛЫН ОЙРХИ ТҮҮХИЙН АСУУДЛУУД

улс төрийн өндөр албан тушаалд дэвшсэн бөгөөд намын төв хорооны тэргүүлэгч, нарийн бичгийн дарга, шалган байцаах комиссын даргаас доошгүй, төрийн сайдаас доошгүй албан тушаалыг хашиж байсан ба энэ нь бусад бүлгүүдтэй (бусад бүлгүүдийн талаар 9-р хэсэгт өгүүлнэ,) харьцуулбал хоёрдугаарт орж байжээ. Хэрвээ дэд сайд, түүнтэй тэнцэх албан тушаал, намын төв хорооны гишүүн, орлогч, хэлстийн дарга, шалган байцаах комиссын гишүүнийг оролцуулбал энэ тоо нэлээд ихэснэ. Энэ бол чамгүй өндөр тоо юм. Эдгээр хүмүүсийн замнал нь цэргээс шууд аль нэгэн албан газар, орон нутгийн сонгуульт ажлыг эрхэлж байгаад шат дараалан дэвшжээ. Тэд харьцангуй бичиг үсэгтэй, зарим нь бүр Хужирбулангийн цэргийн боловсролтой хүмүүс юм. Ингэж жирийн цэргээс шат дараалан дэвшсээр байгаад прокурор, дээд шүүхийн гишүүн хүртэл болж байв.

1913-1919 онд Хужирбуланд цэргийн албыг хаасан. 1921 оны партизан. 1922 онд цэргээс халагдаад 1924 оноос шүүх яаманд бичээч, нягтлан бодогч, туслах түшмэл, 1931 оноос Завхан, Төв, Хөвсгөл аймгийн прокурор, БНМАУ-ын Дээд шүүхийн гишүүн, Шүүх яаманд зааварлагч зэрэг ажлыг 1940 он хүртэл хийж байв. 1932 онд гарсан баруун дөрвөн аймагт гарсан хувьсгалын эсрэг хөдөлгөөнийг дарахад идэвхтэй оролцсон байна. (М.Наваанцэдэн, Ардын журамт цэргийн дургалууд, 1985)

Мөн хувь заяагаар холбогдсон цэргийн салбараас ирээдүйд стратегийн чухал ач холбогдолтой холбооны сайд хүртэл ахисан хүн ч бий.

1921 оны партизан, МАХН-д 1922 онд элссэн. 1924 оноос эхлэн цэргийн холбооны анги салбарууд харилцаа холбооны цэрэгжүүлсэн ерөнхий хорооны дарга, Холбооны Яамны сайдаар 1946 он хүртэл ажиллаж байжээ. 1946 оноос БНМАУ-ын Сайд нарын зөвлөл, АИХ-ын тэргүүлэгчдийн газарт байцаагч тусгай эмнэлгийн дарга, засгийн газрын ордны комендант зэрэг ажлыг хашжээ. (Д.Дэндэв, Ардын журамт цэргийн дургалууд, 1985)

Хамгийн түгээмэл хэлбэр нь цэргээс халагдаад намын төв сургуульд суралцаж, мэргэжлийн ухуулагч улс төрийн ажилтны албаар дамжин улмаар сонгуульт албан тушаалд сонгогдож байжээ. Тухайлбал Ш.Лувсаннямыг дурдаж болно.

1921 оны партизан, 1925 онд цэргээс халагдаад Намын төв сургуулийн курст суралцаж төгсөж 1959 он хүртэл нам, улс, эмнэлэг худалдааны байгууллагад ажиллажээ. МАХН-ын X их хурал, Улсын VIII их хуралд төлөөлөгчөөр оролцжээ. (Ш.Лувсанням, Ардын журамт цэргийн дургалууд, 1985)

Мөн цэргийн албанаас цагдаагийн албанд шилжиж улмаар захиргааны ажил хийж байгаад УБХ-ын орлогч дарга хүртэл болсон хүн ч байна.

1921 оны партизан, хувьсгалын дараа Алтанбулаг хотноо сэргийлэх цагдаа, багийн дарга хоршооны ангийн дарга зэрэг ажил хийж байгаад 1934 онд Улсын VII Их хуралд төлөөлөгчөөр орж улмаар УБХ-ын гишүүн, 1938 онд УБХ-ын тэргүүлэгч гишүүн, мөн улсын VIII их хурлаас УБХ-ын орлогч даргаар сонгогджээ. (Ц.Ёндон, Ардын журамт цэргийн дургалууд, 1985)

Ингэж байлдаж явсан хүмүүсийг дэвшүүлэхдээ судалж ажил үүргээ хэрхэн гүйцэтгэж байсан болон өөр бусад олон шалгуураар шүүж байв. Нийтдээ 29 хүн УИХ-д төлөөлөгчөөр сонгогдож өөрийн байгуулсан төрдөө элч төлөөлөгчөөр сонгогдох хүндтэй үүрэг хүлээж явжээ.

9. Технократууд: Сүүлчийн бүлэг бол технократууд юм. Гэвч энэ ойлголт тэр үед тохирохгүй, учир нь уламжлалт мал аж ахуй эрхэлдэг хүмүүсийн хувьд ийм тодорхойлттой хүмүүс байхгүй. Гэхдээ цөөн хэдэн хүн инженер, технологийн чиглэлээр суралцаж ирээдүйн технократуудын армийг бүрдэх эхлэлийг тавина. Зарим талаараа ийм тодорхойлолтод ялимгүй дөхөж очих нэг хүний жишээг харья.

III МОНГОЛЫН ОЙРХИ ТҮҮХИЙН АСУУДЛУУД

1921 оны партизан, 1928 оноос орон нутгийн нам, улс аж ахуйн газар ажиллаж нэгдлийн мал бригад, үйлдвэр, бригадын дарга зэрэг ажил хийж байжээ. 1928 онд МАХН-ын гишүүнд элсжээ. (О.Гэндэн, Ардын журамт цэргийн дуртгалууд, 1982)

Мөн цэргийн албан тушаалаас хоршоодын холбооны дарга болж улмаар аж үйлдвэрийн комбинатын дарга хүртэл хийж явсан нэгний жишээг сонирхуулья.

Манайх угийн мал гэх юмгүй ядуу айл байсан болохоор би хар багас бусдын мал хариулах, мод төмрийн дархан хийх, биеийн хүчин үнэлэн бусдад зарцлагдах зэргээр амьдарч явсан юм. 1921 онд Хатанбаатар Магсаржавын цэрэгт татагдан оров. Би ардын хувьсгалын дараа цэргийн алба үргэлжлэн хааж явлаа. Анх цэргийн гар үйлдвэрт 10 хүн авахад түүнд оролцон очиж ажиллаж байгаад цэргийн ерөнхий сургуульд орж давтан курс хийж цэргийн дарга болсон билээ. ...Пунцаг ардын хувьсгалын дараа салаа, суман, хороо, корпусын дарга, цэргийн прокурор, Хоршоодын холбооны ерөнхий хорооны дарга, Аж үйлдвэрийн комбинатын дарга зэрэг ажил хийж байжээ. Энэ завсраа Зөвлөлтөд Тверийн морин цэргийн сургууль, хоршоодын холбооны дээд курст тус тус суралцаж төгсжээ. Мөн ЗХУ-ын Бүх цэргийн Ардын комиссаратын дарга, маршал Ворошиловоос алтан сэлмээр шагнагдсан байна. (Ө.Пунцаг, Ардын журамт цэргийн дуртгалууд, 1985)

Доор дурдах жишээ бол лидерийн жишээ биш гэхдээ мэргэжлийн боловсролгүй ч ирээдүйн технократууд төрөх салбар болох гар үйлдвэр, сангийн аж ахуй барилгад удирдах алба хашиж явсан хүний нэг юм.

1921 оны партизан, хувьсгалын ялалтын дараа 1924-1938 онд гар үйлдвэр, улсын худалдаа, Жаргалантын сангийн аж ахуй, барилгын байгууллага зэрэг газар албан ажил хийж байв. (Б.Дашцэрэн, Ардын журамт цэргийн дуртгалууд, 1982)

Энэ бүх баримтууд нь партизанууд нь жирийн цэргүүд байгаагүй шинэ нийгэмд эзгүйрсэн улс төрийн тавцанд өөрсдийн дуу хоолой, өнгө төрхтэйгээр гарч ирж хувьсгалын дараах монголын нийгмийг реформ хийх үйлсэд арвин хувь нэмрийг оруулсныг харуулж байна. Ингэж анх хэргэм зэрэг, шашин шүтлэг, эд баялгийн аль нь ч байхгүй 10 гаран хүнтэй эхэлсэн хувьсгалчдын санаачлага Монгол орныг гадны түрэмгийлэгчдээс аврах томоохон хүч болон хувирч, Монголын нийгмийг хөгжлийн өмнөх шатанд гаргаж чаджээ. Амь өрсөн байлдсан олон партизануудын ихэнх нь гол ажил дууссан гэж ойлгож хань ижил, үр хүүхэд, эцэг эх дээрээ эсэн мэнд очин, нутаг усандаа амар жимэр амьдран суухыг хүсч байсан, тэдний хүсэл биелсэн. Гэвч энэ бол хувьсгал тиймээс ажил дуусаагүй, харин ч дөнгөж эхэлж байлаа. 1911 оны үндэсний хувьсгал ялсны дараа Манжийн үед хадгалагдаж үлдсэн засаглалын шаталсан тогтолцоо, засаг захиргааны зохион байгуулалт, засгийн эрх барих язгууртан, лам нар бэлэн тэдний засаглал ч легитими байдал нь (шашин, хууль ёсны, нэр хүндийн, язгуурын) хангалттай үндэслэгдсэн байсан. Тэгвэл 1921 хувьсгалын дараа нөхцөл байдал шал өөр, хувьсгалчид тулаан, байлдаанд амжилт гаргасан хүмүүсийг шагнадаг баатар цолыг аваад л гэртээ харихаар зорилго нь хязгаарлагдаагүй юм. Дахин хуваарилагдаж байгаа их гүрнүүдийн бодлого, эзгүйрсэн улс төрийн тавцан, зайлшгүй хийх ёстой нийгмийн реформ, хувьсгалын аугаа их үйл хэрэг тэднийг хүлээж байлаа. Хувьсгалчид өөрсдийн ирээдүй, өгсөлтөндөө итгэл төгс байсан биз. Гэвч тэднийг олон төрлийн зөрчил, их гүрний хатуу бодлого хүлээж байгаа, олонхи нь хэлмэгдэж цагаасаа эрт ертөнцийн мөнх бусыг үзэх болно. Тэд өөрсдийн бүтээсэн нийгэмдээ төсөөлж байсан шигээ тухалж чадаагүй, үүлэн чөлөөний нарыг харсан. Үр хүүхдүүд нь ч гэсэн хэлмэгдлийн золиос болно. Хэрвээ үүнийг мэдсэн бол олон хүмүүс орон нутаг руугаа явах байсан биз. Хувьсгалчдын нэг бүхэл үе дууссаны дараа цоо шинэ хүмүүс үр дүнг нь хүртэж, ХХ зуун дуустал хагас зуун жил байр суурийг эзлэх болно. Тэдний үр хүүхэд эцэг эхийнхээ гавьяаг хүртэж үе дамжсан элитүүд болно. Хувьсгалчид зөвхөн түүхийн номонд л тэмдэглэгдэн үлдэнэ. Тэгвэл хувьсгалчдыг үр удмаар нь хэлмэгдүүлж, ялгаварлан

III МОНГОЛЫН ОЙРХИ ТҮҮХИЙН АСУУДЛУУД

гадуурхаж байж хувьсгалын үр дүнг хүртсэн энэ хүмүүс хэн байв? Хувьсгалын үр дүнг завшсан, эдгээр хүмүүс гамин, бароны эсрэг амь өрсөн тулалдаагүй, шинэ юмыг үүсгэхийн зовлонг үзээгүй, хувь заяа нь маргааш яаж эргэх бол үргэлж санаа зовох хэрэг байгаагүй, харин эсрэгээрээ нэгэнт тодорхой болчихсон бүтцэд зөв газар нь байрлаж карьераа хөөж албан тушаалд хүрсэн хүмүүс юм. Энэ тухай дараагийн өгүүлэлд бичнэ. Ямар боловч партизаныуд олон зуун жил хадгалагдсан уламжлалт нийгмийг модернизаци хийх аугаа үйлсийн шавыг тавьсан. Чухам энэ өдрийг хүртэл бие хүн социал статусаа дээшлүүлэхийн тулд язгууртны гэр бүлд төрөхөөс гадна лам болох, дайнд байлдаанд явах байсан бол шинэ цаг үед сургууль, курс төгсөх, цэрэгт явах, намд элсэх болж солигдсон. Ингэж угсаа залгамжлах хамжлагт ёсыг улс төрийн нам, шашны үүргийг сургууль гүйцэтгэж эхэлсний гавьяа нь малчин-партизаныудад ноогдоно. Үүгээрээ жирийн малчин гэр бүлээс гаралтай, мал маллах, биеийн хүчээ үнэлдэг байсан, өнчин өрөөсөн олон хүмүүс нийгмийн статусаа дээшлүүлж чадсан. Уг нь тэд шинэ цагийн эзэд, дараагийн номенклатурчдын эцэг болох байсан нь эргэлзээгүй.

(Үргэлжлэл бий.)

III МОНГОЛЫН ОЙРХИ ТҮҮХИЙН АСУУДЛУУД

Abstract

Partisans and results of revolution

The article's objective is to test the main hypothesis which is "revolution in the 1921" of Mongolia is a continuation of the unfinished national independence revolution of 1911, by comparing participant's partisan's case of mass mobilization.

The purpose of this research paper is to define the role of partisans in the revolution at the 1921. The author used qualities and quantities methods historical sociological methods of memoir's of partisans approach to this historical study.

The research will focus particularly on partisan's memoir and the research scope is limited by their participation in 1921 revolutions. Author concluded that this research can prove that 1921 revolution are continuation of 1911 revolution.

Bibliography

- (1982). In *Ардын журамт цэргийн дурдатгалууд*.
Баабар. (2006). *Монголчууд: нүүдэл суудал.2* УБ: Соёмбо принтинг.
С.В. Милс. (1956). *The Power elite*. Oxford.
Ардын журамт цэргийн дурдатгалууд. (1969). УБ.
Б.Шарав. (1986). In *Монгол ардын журамт цэргийн дурдатгалууд*. УБ.
Г.Мягмарсамбуу. (2001). Цэргийн даргалах бүрэлдхүүн. In *Хоёрдугаар зууны монгол цэрэг* (pp. 95-116). УБ: Алтан үсэг.
Д.Өлзийбаатар. (2004). *Яагаад 1937 он.* УБ.
Ж.Болдбаатар, Ч.Дашдаваа. (2005). *Шинэчлэлийн төлөө хөдөлгөөн, түүний хувь заяа*. УБ: Соёмбо .
З.Лонжид, Г.Дашням. (1996). Нам хувьсгалын түүхийн сурвалж бүтээл. *Эрдэм шинжилгээний бичиг (МУИС-нийгмийн ухаан)* , 83-99.
МАХН их, бага хурал, төв хорооны бүгд хурлуудын тогтоол шийдвэр. (1956). УБ: Улсын хэвлэлийн газар.
Монгол ардын хувьсгалт намын түүхэн замнал. (1995). Улаанбаатар: Мана.
О.Батсайхан. (2003). Хувьсгалын үндэсний ардчилсан зорилтыг хэрэгжүүлэх оролдлого (1925-1953). In *Монгол улсын түүх. тавдугаар боть. (XX зуун)* (pp. 169-184). Улаанбаатар: Адмон.
С.Гангааням. (1991). Монгол ардын хувьсгалт цэргийн дээд удирдлага: цаг үе, хүмүүс (1921-1940). In *Монгол цэргийн уламжлал, хөгжил* (pp. 80-124). Улаанбаатар: Армийн хэвлэх үйлдвэр.
С.Идшинов, Г.Цэрэндорж. (1991). Хаант монгол улсын цэргийн зохион байгуулалт. In *Монгол цэргийн уламжлал, хөгжил* (pp. 16-27). УБ: Армийн хэвлэх үйлдвэр.
Х.Гүндсамбуу. (2002). *Монголын нийгмийн давхраажил: хөгжил хандлага (XX зуунд)*. Улаанбаатар.
Ч.Болдбаатар. (2004). *XX зууны монголын улс төрийн зүтгэлтнүүд*. УБ.
Ч.Ганбаатар. (1991). Ардын журамт цэргээс байнгын цэрэг болж хөгжсөн түүхийн асуудалд. In *Монголын цэргийн уламжлал, хөгжил* (pp. 27-35). УБ: Армийн хэвлэх үйлдвэр.
Э.Гидденс. (2007). *Социологи*. УБ.